

Loro Piana

УЛААНБААТАР ХОТЫН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНЫ НУТАГ
ДЭВСГЭРТ ХЭРЭГЖИЖ БУЙ “ЛОРО ПЬЯНА МОНГОЛ” ХХК-ИЙН “ХИМИ БОЛОН
БИОЛОГИЙН АРГААР БОХИР УС ЦЭВЭРШҮҮЛЭХ БАЙГУУЛАМЖ” ТӨСЛИЙН
2026 ОНЫ ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

ХЯНАСАН:
“ЛОРО ПЬЯНА МОНГОЛ” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ

Б.ХУЛАН

БОЛОВСРУУЛСАН:
“МОН ГАЗАР ЭКОЛОГИ” ХХК-ИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН

О.САРАНГОО

ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
1.1. Төслийн нэр	3
1.2. Төсөл хэрэгжүүлэгч	3
1.3. Төслийн байршил	3
1.4. Төслийн танилцуулга	4
1.5. Технологи ажиллагаа	8
1.6. Бохир ус цэвэрлэх байгууламж	9
1.7. Төслийн хүчин чадал	10
1.8. Төслийн дэд бүтэц	10
1.9. Ус хэрэглээ	11
2. БАЙГАЛЬ ОРЧНЫ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ.....	17
2.1. Байгаль орчны бүрдэл хэсэгт үзүүлэх болзошгүй сөрөг нөлөө	17
2.1.1. БОННУ-ээр тогтоосон нөлөөллүүд	17
2.1.2. Төслийн үйл ажиллагаатай холбоотой нөлөөллийн тодорхойлолт	18
2.1.3. Усны ашиглалтаас үүсэх нөлөө	18
2.2. Ноолуур боловсруулах үйлдвэрийн ажлын байрны орчин	19
2.3. Хог хаягдлын эх үүсвэртэй холбоотой нөлөөллийн тодорхойлолт	19
3. 2026 ОНЫ ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	21
4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	23
5. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	25
6. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	26
7. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	27
8. УДИРДЛАГА-ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	28
9. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	29
10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	30
11. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	31
12. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	32
13. ДҮГНЭЛТ	33

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Үйлдвэрийн талбайн газрын солбицол	3
Хүснэгт 2. Товч танилцуулга	7
Хүснэгт 3. Үйлдвэрийн технологи шат дамжлага	8
Хүснэгт 4. Унд ахуйн ус хэрэглээний тооцоо	11
Хүснэгт 5. Технологийн ус хэрэглээний тооцоо-1	12
Хүснэгт 6. Технологийн ус хэрэглээний тооцоо /эргэлтийн системийн тооцоо болон бодит зарцуулалт/	13
Хүснэгт 7. Ногоон байгууламжийн ус хэрэглээний тооцоо.....	14
Хүснэгт 8. Худгийн мэдээлэл	16
Хүснэгт 9. БОННУ-ний тодотгол хийгдсэн нөлөөллүүд.....	17
Хүснэгт 10. Газар ашиглалтын тодотгол ба дүн шинжилгээ.....	17
Хүснэгт 11. Төслийн үйл ажиллагаатай холбоотой нөлөөллийн тодорхойлолт	18
Хүснэгт 12. Төслийн усны бодит хэрэглээ, ус ашиглалтын нормоор тооцсон хэмжээ ...	18
Хүснэгт 13. Ажлын байрны орчин, нөхцөлүүдээс үзүүлэх нөлөөллийн тодорхойлолт ..	19
Хүснэгт 14. Төслийн хүрэн дэх хог хаягдлаас үүсэх нөлөөллийн тодорхойлолт	19
Хүснэгт 15. Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөний 2026 оны зардал	33

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн байршлын тойм зураг	3
Зураг 2. Ноолуур боловсруулах үйлдвэрийн орчны зураг	4
Зураг 3. Түүхий эд хүлээн авах агуулах.....	4
Зураг 4. Түүхий эд ангиан ялгах хэсэг	4
Зураг 5. Ноолуур сэмлэх, сэгсрэх, угаах хэсэг	5
Зураг 6. Самнах ялгах хэсэг	5
Зураг 7. Бохир ус цэвэрлэх байгууламж	5
Зураг 8. Үйлдвэрийн одоо байгаа агааржуулалтын систем	5
Зураг 9. Үйлдвэрийн ариун цэврийн өрөө	6
Зураг 10. Бүтээгдэхүүний лаборатори	6
Зураг 11. Химийн бодисын агуулах	6
Зураг 12. Үйлдвэрийн дотоод зам талбай.....	6
Зураг 13. Ногоон байгууламж, сул чөлөөтэй талбай	7
Зураг 14. Биологийн ус цэвэрлэх байгууламжийн технологийн схем	9
Зураг 15. Хими биологийн аргаар ус цэвэрлэх байгууламж.....	10
Зураг 16. Төслийн талбайгаас төв зам хүртэлх зай.....	11
Зураг 17. Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн ус ашиглалт болон бүтгэлдэхүүний тоо мэдээллийг Итали улсад байрлах төв салбараас ирсэн ERP дата мэдээлэл	13

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн нэр


“Лоро Пьяна Монгол” ХХК-ийн “Хими болон биологийн аргаар бохир ус цэвэршүүлэх байгууламж”

1.2. Төсөл хэрэгжүүлэгч

Төсөл хэрэгжүүлэгч: “Лоро Пьяна Монгол” ХХК
 Улсын бүртгэлийн дугаар: 9019011059
 Регистрийн дугаар: 2046237
 Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Өөрийн байр-00.
 Холбоо барих утас: 1134-3529, 9911-5458

1.3. Төслийн байршил

“Лоро Пьяна Монгол” ХХК-ийн “Хими болон биологийн аргаар бохир ус цэвэршүүлэх байгууламж” төсөл нь Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 3-р хорооны нутагт эзэмшил газрын хэмжээ 10980.0 м² байна.



Зураг 1. Төслийн байршлын тойм зураг

Хүснэгт 1. Үйлдвэрийн талбайн газрын солбицол

№	Солбицол			Солбицол	
1	640499.00	5306858.00	13	640700.00	5306844.00
2	640529.00	5306878.0	14	640674.00	5306828.00
3	640534.00	5306872.00	15	640664.00	5306822.00
4	640541.0	5306859.00	16	640660.00	5306827.00
5	640552.00	5306866.00	17	640657.00	5306833.00
6	640564.00	5306847.00	18	640644.00	5306854.00
7	640626.00	5306884.00	19	640639.00	5306854.00
8	640606.00	5306916.00	20	640646.00	5306839.00
9	640625.00	5306927.00	21	640580.00	5306801.00
10	640625.00	5306927.00	22	640575.00	5306798.00

11	640636.00	5306934.00	23	640573.00	5306798.00
12	640644.00	5306938.00			

1.4. Төслийн танилцуулга

“Лоро Пьяна Монгол” ХХК нь 1997 онд Итали улсын 100%-ийн хөрөнгө оруулалттай экспорт, импорт, ямааны ноолуур боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр байгуулагдсан байна. Тус компанийн хөрөнгө оруулагч нь дэлхийн нэртэй Луи Витон (Louis Vuitton) корпорацын охин компани болох Италийн Лоро Пьяна СпА компани юм.



Зураг 2. Ноолуур боловсруулах үйлдвэрийн орчны зураг



Зураг 3. Түүхий эд хүлээн авах агуулах



Зураг 4. Түүхий эд ангилан ялгах хэсэг




Зураг 5. Ноолуур сэмлэх, сэгерэх, угаах хэсэг




Зураг 6. Самнах ялгах хэсэг



Зураг 7. Бохир ус цэвэрлэх байгууламж



Зураг 8. Үйлдвэрийн одоо байгаа агааржуулалтын систем



Зураг 9. Үйлдвэрийн ариун цэврийн өрөө




Зураг 10. Бүтээгдэхүүний лаборатори



Зураг 11. Химийн бодисын агуулах



Зураг 12. Үйлдвэрийн дотоод зам талбай



Зураг 13. Ногоон байгууламж, сул чөлөөтэй талбай

Хүснэгт 2. Товч танилцуулга

Үйл ажиллагааны үндсэн чиглэл:	Ноолуур боловсруулах, самнасан ноолуур экспортод гаргах
Борлуулалтын хэмжээ:	Жилд 260-280 тонн түүхий ноолуур худалдан авч угааж самнан 130-140 тонн самнасан ноолуур гарах хучин чадалтай.
Барилга байгууламж:	Төвийн халаалт, цэвэр, бохир усны төвлөрсөн системд холбогдсон хоёр давхар тоосгон барилга, угаах самнах цехийн өргөтгөл, ус цэвэрлэх байгууламж
Тоног төхөөрөмж:	Японы Togiee самнах машин, Хятадын FB 006-100 угаах машин, FN288, A-186 Cotton card самнах машинууд, Италийн ус цэвэрлэх байгууламжийн тоног төхөөрөмжүүд, Австрали, Италийн лабораторийн техник хэрэгслүүд
Хүний нөөц:	Нийт 52 ажилчин, албан хаагчидтай

Хөрөнгө оруулагч Лоро Пьяна СпА нь 2000 онд Хан-Уул дүүрэгт байрлах ноолуурын анхан шатны боловсруулалт хийх үйлдвэрийг худалдан авч үйлдвэрлэлээ эхлүүлснээс хойш тасралтгүй ажиллаж байгаа. 2007, 2009 онуудад үйлдвэрийн тоног төхөөрөмжийг өргөтгөн шинээр суурилуулж, хялгас ялгах цехийн өргөтгөл, ноолуур угаах цехийн барилгуудыг барьсан байна.

Компани нь жилд 30,0-40,0 тэрбум төгрөгийн ямааны түүхий ноолуур худалдан авч боловсруулдаг ба 2001 оноос хойш малчдаас 415,6 тэрбум төгрөгийн ноолуур худалдан авсан байна. Бид авсан ноолуураа холбогдох стандартын дагуу ангилж, угааж самнан, боловсруулсан ноолуураа Итали улс руу 100% экспортолдог. Ямааны түүхий ноолуураа боловсруулахдаа сүүлийн үеийн болон Япон, Хятад улсуудын угаах, самнах тоног төхөөрөмж, сонгодог технологи ашигладаг байна

Монгол улсын цэвэр усны нөөц хомсдоход ойрхон байгаа өнөө үед бид үйлдвэрлэлдээ ус цэвэршүүлэх шинэ технологи нэвтрүүлж, усны нөөц, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулахад анхааран ажиллаж байна. Бид ноолуур угаасан бохир усыг химийн аргаар 90% хүртэл цэвэршүүлэх Итали улсын тоног төхөөрөмжийг анх 2012 онд угсарч суурилуулан, улмаар 2023 онд биологийн аргаар мембран реактороор оруулан бохир усыг 99% цэвэрлэдэг 1.4 сая еврогийн өртөгтэй ус цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулсан.

Компанийн дүрмийн сан өнөөдрийн байдлаар 8,7 тэрбум төгрөгт хүрч, нийт 19,5 тэрбум төгрөгийн өртөг бүхий үндсэн хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаагаа явуулж байна.

Манай компани 2001 оноос хойш 2025 оны 09 сар хүртэл улсын төсөвт 3,7 тэрбум төгрөгийн аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлснөөс сүүлийн гурван жилд 1,6

тэрбум төгрөг, бусад төрлийн татварт 454,5 сая төгрөг төлж улсын төсөвт төвлөрүүлсэн байна.



2022 онд Байгаль орчны менежментийн тогтолцооны ISO 14001:2015 олон улсын стандартыг хангаж Ноолуур ангилах, угаах, самнах болон илгээх үйл ажиллагаандаа гэрчилгээ авсан. Мөн Тогтвортой ноос ноолуурын эвслийн ноолуурын стандартын анхан шатны боловсруулах үйлдвэрийн тохирлын SCS-054-01-0-EN, MNS ISO/IEC 17065:2013, MNS ISO/IEC 17067:2013 шалгуурыг хангаж Алтан гэрчилгээ авсан.

2025 оны 9 сард манай компанид Гаалийн Ерөнхий газраас “Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж” гэсэн итгэмжлэлийг олгосон. Тус итгэмжлэлийг хууль сахилтын түвшин өндөр, дотоод хяналт сайн, гадаад худалдааны аюулгүй байдлын стандартыг чанд сахин мөрддөг, санхүүгийн чадавх сайн олгодог байна. Одоогийн байдлаар нийт 6 аж ахуйн нэгжид энэхүү итгэмжлэлийг Гаалийн Ерөнхий газраас олгоод байна.

1.5. Технологи ажиллагаа


Хүснэгт 3. Үйлдвэрийн технологи шат дамжлага

<p>Түүхий эд хүлээн авах</p>	
<p>Ангилан ялгах</p>	
<p>Ноолуур угаах дамжлага</p>	
<p>Үйлдвэрийн хаягдал ус цэвэрлэх байгууламж</p>	

<p>Самнах, Ялгах</p>	
<p>Самнасан ноолуурыг пресслэх, агуулах</p>	

1.6. Бохир ус цэвэрлэх байгууламж

Тус анхан шатны боловсруулах үйлдвэр нь Итали болон Европын холбооны улсуудад үйлдвэрлэсэн MBR технологи ашиглан хаягдал усыг 99.9% хүртэл цэвэршүүлж хаягдал усны 20.0%-ыг үйлдвэрийн угаах дамжлагын 1, 2 хэсэгт дахин ашиглаж, үлдсэн хаягдал усыг УСУГ-ын 2020.06.02 өдрийн бохир усыг татан зайлуулах гэрээний дагуу зайлуулж байна. “Хими болон биологийн аргаар ус цэвэршүүлэх байгууламж” нь ноолуур боловсруулах үйлдвэрийн бохир усыг бүрэн цэвэрлэхийн тулд химийн хүчилтөрөгчийн хэрэгцээгээр хэмжигддэг органик бодис, гадаргын идэвхтэй бодис, аммиак болон органик азот зэргийг нэгэн зэрэг цэвэрлэх шийдэлтэй. Цэвэршүүлэх үйл явц нь биологийн нитратжуулах болон үл нитратжуулах процессын тусламжтай явагдах ба исэлдэлд/нитратжуулалтын үе шатанд органик нэгдлүүд болон гадаргын идэвхт бодисууд устаж, бактерийг нитратжуулснаар органик азот/аммиак азот нь дараагийн үл-нитратжуулах үе шатанд азот болон исэлдэж, хийн төлөвтэй болж буурна. Биологийн цэвэрлэх байгууламжийн тогтвортой ажиллагааг хангахад цэвэрлэх байгууламжийн орчны температур 15 хэмээс доошгүй байх шаардлагатай ба шинэ байгууламжийн зураг төсөл нь энэ нөхцөлийг бүрдүүлэх шийдэлтэй, байгууламжийн үл-нитритжүүлэх савны хүчин чадал 50м³, исэлдэлтийн хэсгийн багтаамж 60м³ байна.



Зураг 14. Биологийн ус цэвэрлэх байгууламжийн технологийн схем



Зураг 15. Хими биологийн аргаар ус цэвэрлэх байгууламж

1.7. Төслийн хүчин чадал

“Лоро Пьяна Монгол” ХХК-ийн “Хими болон биологийн аргаар бохир ус цэвэршүүлэх байгууламж” төсөл нь түүхий эдийн нийлүүлэлтээс хамааран жилд 260-280 тонн түүхий ноолуур худалдан авч угааж самнан 130-140 тонн самнасан ноолуур үйлдвэрлэдэг ба нийт 52 ба үүнээс үйлдвэрийн цехэд 30 хүн, захиргаа оффист 22 хүн ажилладаг ба жилд 300 хоног ажиллах хүчин чадалтай байна.

1.8. Төслийн дэд бүтэц

Төслийн талбай орчинд зам тээвэр, харилцаа холбоо, эрчим хүч, цахилгаан хангамж зэрэг дэд бүтэц сайн хөгжсөн.

Цахилгаан хангамж: Цахилгаан хангамжийн хувьд төвийн эрчим хүчний системд бүрэн холбогдсон байна.

Дулаан хангамж: Тус төсөл нь дулаан хангамжийг төвийн дулаан хангамжаас бүрэн хангаж байна.

Цэвэр усны хангамж: Тус төсөл нь технологийн ус хэрэглээг өөрийн эзэмшлийн 5.0 л/с ундаргатай гүний худгаас, унд ахуй, ногоон байгууламжийн ус хэрэглээг Ус сувгийн удирдах газартай 2020.06.02 өдрийн “Цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг тат зайлуулах гэрээний дагуу Улаанбаатар хотын хотын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрээс хангадаг болно.

Харилцаа холбоо: Холбоо мэдээллийн хувьд бүх үүрэн телефон холбоо ашиглах боломжтой.

Зам харилцаа: Үйлдвэрийн баруун болон хойд хэсэг нь хатуу хучилттай зам талбай болон Говийн үйлдвэрийн гудамжны төвийн автозам дагуу байрлах бөгөөд тус орчин нь бүхэлдээ хатуу хучилттай автозамаар холбогдсон байна.



Зураг 16. Төслийн талбайгаас төв зам хүртэлх зай

1.9. Ус хэрэглээ

“Лоро Пьяна Монгол” ХХК-ийн “Ноолуур боловсруулах үйлдвэр” төсөл нь ажилчдын унд-ахуй болон үйлдвэрийн технологид ус ашиглана. Ус хэрэглээг төслийн талбай дахь 5.0 л/с ундаргатай гүний худаг болон Ус сувгийн удирдах газартай 2020.06.02 өдрийн “Цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах гэрээ”-ний дагуу Улаанбаатар хотын хотын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрээс тус тус хангаж байна.

Унд ахуйн ус хэрэглээ: Тус төсөл нь 52 хүн ажиллах бөгөөд үүний үүнээс үйлдвэрийн цехэд 30 хүн, захиргаа оффист 22 хүн ажилладаг ба жилд 300 хоног ажиллах хүчин чадалтай бөгөөд ажилчдын унд ахуйн хэрэгцээнд ашиглах усны нийт хэмжээг БОНХАЖЯ-ны сайдын 2015 А-301 тоот тушаалаар батлагдсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм батлах тухай” тушаалын 14 дугаар хавсралтын “Нийтийн болон ахуйн үйлчилгээний газруудын ус хэрэглээний норм”-ын 31 дэх заалт “Албан байгууллага” ангиллаар 80.0 л нормоор тооцов.

“Лоро Пьяна Монгол” ХХК -ийн “Ноолуур боловсруулах үйлдвэр” төсөл нь түүхий эдийн олдцоос хамааран жилд 260-280 тонн түүхий ноолуур худалдан авч угааж самнан 130-140 тонн самнасан ноолуур үйлдвэрлэдэг ба нийт 52 ажилтантай ба үүнээс үйлдвэрийн цехэд 30 хүн, захиргаа оффист 22 хүн ажилладаг ба жилд 300 хоног ажиллах хүчин чадалтай байна.

Хүснэгт 4. Унд ахуйн ус хэрэглээний тооцоо

Унд ахуйн усны хэрэглээ				
Хүчин чадал (хүн)	Норм, л	Хоногт, л	Сард, м ³	Төсөл хэрэгжих нэг жилд, м ³
Нийт ажилчид	52	80	4160	124.8
Нийт	Өдөрт 4.1м³, сард 124.8 м³, жилд 1248.0 м³			

1 сарын 30 хоног, 1 жилийг 300 хоногоор тооцов

Технологийн усны хэрэглээнд:

“Лоро Пьяна Монгол” ХХК-ийн “Ноолуур боловсруулах үйлдвэр” төсөл нь түүхий эдийн олдцоос хамааран жилд 260-280 тонн түүхий ноолуур худалдан авч угааж самнан 130-140 тонн самнасан ноолуур үйлдвэрлэх хүчин чадалтай бөгөөд технологийн ус хэрэглээг тооцоходоо БОНХАЖЯ-ны сайдын 2015 оны А/301 тоот тушаалаар батлагдсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм”-ын 4-р хавсралт хөнгөн үйлдвэрийн салбарын ноосны үйлдвэрийн 1тн ноолуур угаахад 66.7 м³ нормоор тооцоолсон болно.

Хүснэгт 5. Технологийн ус хэрэглээний тооцоо-1

Технологит ашиглах усны хэрэглээ			
Хүчин чадал, жил	Нийт ус хэрэглээ	Технологийн хэрэгцээнд м³	Ахуйн хэрэгцээнд м³
Норм, м³	66.7	64.2	2.5
Өдөрт 0.77 тн Сард 23.3 тн Жилд 280 тн	Хоногт / м³/	Сард / м³/	Жилд /м³/
	51.3	1554.11	18676.0
Үйлдвэрийн бодит ус хэрэглээгээр			
Нийт 39.0 м³/хон	39.0	1170.0	11700.0
Бодит зарцуулалт 32.0 м³/хон	32.0	960.0	9600.0

1 сарын 30 хоног, 1 жилийг 300 хоногоор тооцов

Үйлдвэрийн угаах цех нийт 5 танктай ба эхний 3 танканд сод, саван хийн түүхий ноолуурын зунгаг тослог, шороо, хаг, хогт хольцыг угаан цэвэрлэх ба 4, 5 дахь танкны зайлах дамжлагын шатанд ноолуур зайлсан усыг 1 дүгээр танк руу сэлбэлтээр хийж дахин ашигладаг.

Сэлбэлтээр ашиглах усны хэмжээг дараах байдлаар тооцоолов. Үүнд: Тус үйлдвэрийн тоног төхөөрөмжийн ус ашиглалт болон эхний бүтээгдэхүүн болон эцсийн бүтгэлдэхүүний тоо мэдээллийг компьютер программ дээр мэдээлэл шууд гардаг бөгөөд Итали улсад байрлах төв салбараас ирсэн ERP дата мэдээллийг авч эргэлтээр ашиглах усны хэмжээг тооцоолов.

2025.06.01-06.30-ны өдрийн хоорондох мэдээллийг үндэслэн тооцоолов. 2025.06.01-06.30-ны өдрийн байдлаар нийт 30 хоногийн хугацаанд ажилласан 24 өдөрт нийт самнах руу 28,072 кг, өдөрт 1,170 кг ноос өгч нийт 21,806 кг, өдөрт 908 кг самнасан ноос гарсан ба үүний ус хэрэглээнд нийт 787м³ ус ашиглагдсан бөгөөд үйлдвэрийн угаах цех нийт 5 танктай бөгөөд өдөрт 1, 2-р танк 7.5 м³, 3,4,5-р танк 6.0 м³ ус, ээлжийн явцад гарах алдагдал 1 м³, хуурайшсан ноолууранд агуулагддаг ус 2 м³, ээлж дуусах бүрт сав цэвэрлэхэд 3 м³ буюу хоногт 39.0 м³/хон ба үүнээс бодит зарцуулалт 32.0 м³/хон ус байна.

Энэхүү 7.0 м³ усны зөрүү нь Т1 ашиглагдах 7 м³ усыг Т4 болон Т5 танканд ашиглагдсан усыг шилжүүлэн эргэлтээр ашигладаг усны хэмжээ бөгөөд танкнудын өдөр тутмын усны хэрэглээний ойролцоогоор 16-20%-тай тэнцэнэ.

Advance date	Product Color	Lot	Sent to Scouring Qty	Scoured KG	Yield %	Dust KG	Dust %	Grease, loss in the water	Soap	Soda	
2025.0608	TE205 Eastern Ligh Grey Cashmere GREIGE	C-25901203-0	Total to 2025.0608	1200,40	881,90	73,47 %	34,50	2,87 %	284,00	23,90	15,10
2025.0609	TE205 Eastern Ligh Grey Cashmere GREIGE	C-25901203-0	Total to 2025.0609	1227,60	919,10	74,87 %	38,60	3,14 %	269,90	25,80	17,90
2025.0610	TE205 Eastern Ligh Grey Cashmere GREIGE	C-25901203-0	Total to 2025.0610	1272,90	891,00	70,00 %	95,90	7,53 %	286,00	28,60	15,10
2025.0611	TE205 Eastern Ligh Grey Cashmere GREIGE	C-25901203-0	Total to 2025.0611	1181,70	837,50	70,87 %	88,00	7,45 %	256,20	25,70	17,80
2025.0612	TE205 Eastern Ligh Grey Cashmere GREIGE	C-25901201-0	Total to 2025.0612	1120,60	834,30	74,45 %	43,10	3,85 %	243,20	23,30	18,10
2025.0613	TE205 Eastern Ligh Grey Cashmere GREIGE	C-25901203-0	Total to 2025.0613	1153,00	839,40	72,80 %	70,30	6,10 %	243,30	25,10	17,20
2025.0614	TE205 Eastern Ligh Grey Cashmere GREIGE	C-25901201-0	Total to 2025.0614	942,80	701,30	74,40 %	50,30	5,34 %	191,00	22,20	15,80
2025.0615	TE205 Eastern Ligh Grey Cashmere GREIGE	C-25901201-0	Total to 2025.0615	1046,10	780,70	74,63 %	46,10	4,41 %	219,30	21,60	16,70
2025.0616	TE205 Eastern Ligh Grey Cashmere GREIGE	C-25901203-0	Total to 2025.0616	1295,30	987,70	76,25 %	45,00	3,47 %	262,60	27,00	18,20
2025.0617	TE205 Eastern Ligh Grey Cashmere GREIGE	C-25901203-0	Total to 2025.0617	1261,30	946,00	75,00 %	44,90	3,56 %	270,40	27,70	19,00
2025.0618	TE205 Eastern Ligh Grey Cashmere GREIGE	C-25901201-0	Total to 2025.0618	1251,20	941,10	75,22 %	40,20	3,22 %	269,80	26,40	17,60
2025.0619	TE205 Eastern Ligh Grey Cashmere GREIGE	C-25901201-0	Total to 2025.0619	1053,80	787,70	74,75 %	32,70	3,10 %	233,40	23,60	17,60
2025.0620	TE205 Eastern Ligh Grey Cashmere GREIGE	C-25901201-0	Total to 2025.0620	1093,30	817,80	74,80 %	22,00	2,01 %	253,50	24,40	15,60
2025.0621	TE205 Eastern Ligh Grey Cashmere GREIGE	C-25901203-0	Total to 2025.0621	1103,80	858,50	77,78 %	31,80	2,88 %	213,50	24,40	16,90
2025.0622	TE205 Eastern Ligh Grey Cashmere GREIGE	C-25901201-0	Total to 2025.0622	1041,60	797,10	76,53 %	34,30	3,29 %	210,20	23,00	15,90
2025.0623	TE205 Eastern Ligh Grey Cashmere GREIGE	C-25901203-0	Total to 2025.0623	1304,40	1023,60	78,47 %	47,10	3,61 %	233,70	26,40	17,50
2025.0624	TE205 Eastern Ligh Grey Cashmere GREIGE	C-25901201-0	Total to 2025.0624	1315,70	1015,80	77,21 %	34,20	2,60 %	265,70	25,90	19,70
2025.0625	TE205 Eastern Ligh Grey Cashmere GREIGE	C-25901201-0	Total to 2025.0625	1294,40	1001,00	77,33 %	39,00	3,01 %	254,40	24,90	20,20
2025.0626	TE205 Eastern Ligh Grey Cashmere GREIGE	C-25901201-0	Total to 2025.0626	1313,00	1014,70	77,28 %	47,20	3,59 %	251,10	25,30	16,20
2025.0627	TE205 Eastern Ligh Grey Cashmere GREIGE	C-25901201-0	Total to 2025.0627	972,90	723,90	74,41 %	44,40	4,56 %	204,60	20,10	16,70
2025.0628	TE205 Eastern Ligh Grey Cashmere GREIGE	C-25901201-0	Total to 2025.0628	1020,00	787,20	77,18 %	33,10	3,25 %	199,70	20,90	10,30
2025.0629	TE205 Eastern Ligh Grey Cashmere GREIGE	C-25901201-0	Total to 2025.0629	996,30	755,80	75,86 %	36,60	3,67 %	203,90	20,40	15,90
2025.0630	TE205 Eastern Ligh Grey Cashmere GREIGE	C-25901203-0	Total to 2025.0630	1319,30	1002,70	76,00 %	57,90	4,39 %	258,70	25,20	14,80
2025.0701	TE205 Eastern Ligh Grey Cashmere GREIGE	C-25902002-0	Total to 2025.0701	1290,80	940,70	72,88 %	43,90	3,40 %	306,20	25,70	18,70
Total				28 072,00	21 086,50	75,12%	1 101,20	3,92%	5 884,30	589,50	404,30

Data	Posso [m3]	Lavaggio [m3]	Chimico Fisico FTT-031 [m3]	Ingresso MBR	Uscita MBR
08-06-2025	45	39	12	5	6
09-06-2025	44	39	35	24	27
10-06-2025	49	39	35	29	31
11-06-2025	36	32	35	31	31
12-06-2025	40	32	34	27	29
13-06-2025	43	36	38	38	37
14-06-2025	38	32	37	38	39
15-06-2025	38	32	36	36	37
16-06-2025	39	34	34	32	33
17-06-2025	33	31	41	36	36
18-06-2025	19	17	46	40	41
19-06-2025	56	45	38	31	32
20-06-2025	23	23	40	34	35
21-06-2025	35	26	33	26	24
22-06-2025	36	31	40	32	31
23-06-2025	35	30	39	36	35
24-06-2025	33	30	37	33	33
25-06-2025	45	38	46	40	39
26-06-2025	51	44	46	45	45
27-06-2025	38	33	38	37	38
28-06-2025	35	31	32	31	31
29-06-2025	31	31	35	34	34
30-06-2025	38	33	45	34	33
TOTALE	920	787	880	766	774

Зураг 17. Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн ус ашиглалт болон бүтгэлдэхүүний тоо мэдээллийг Итали улсад байрлах төв салбараас ирсэн ERP дата мэдээлэл

Хүснэгт 6. Технологийн ус хэрэглээний тооцоо /эргэлтийн системийн тооцоо болон бодит зарцуулалт/

Технологит ашиглах усны хэрэглээ			
Хүчин чадал, жил	Нийт ус хэрэглээ	Технологийн хэрэгцээнд м ³	Ахуйн хэрэгцээнд м ³
Норм, м ³	66.7	64.2	2.5
Өдөрт 0.77 тн Сард 23.3 тн Жилд 280 тн	Хоногт / м ³ /	Сард / м ³ /	Жилд /м ³ /
	51.3	1554.11	18676.0
T4 болон T5 танканд ашиглагдсан усыг эргэлтээр ашиглахад	43.0	1305.4	15687.8
Үйлдвэрийн бодит ус хэрэглээгээр			
Нийт 39.0 м ³ /хон	39.0	1170.0	11700.0
Бодит зарцуулалт 32.0 м ³ /хон	32.0	960.0	9600.0

Одоогийн байдлаар цэвэршүүлэх байгууламжаас гарсан усыг угаах цехэд ашиглахгүй байгаа бөгөөд ашиглах талаар тооцоолол хийгдэж байна.

Нормоор: “Лоро Пьяна Монгол” ХХК-ийн “Ноолуур боловсруулах үйлдвэр” төсөл нь түүхий эдийн олдцоос хамааран жилд 260-280 тонн түүхий ноолуур худалдан авч угааж самнан 130-140 тонн самнасан ноолуур үйлдвэрлэх хүчин чадалтай бөгөөд технологийн ус хэрэглээг БОНХАЖЯ-ны сайдын 2015 оны А/301 тоот “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм”-ын 1тн ноолуур угаахад 66.7 м³ нормоор тооцоолоход хоногт 51.3 м³, сард 1554.1 м³, жилд 18676.0 м³ ба Т1 ашиглагдах усыг Т4 болон Т5 танканд ашиглагдсан усыг шилжүүлэн эргэлтээр ашиглах эргэлтийн тооцоогоор нийт ашигласан усны хэмжээ болох нийт ашиглах усны тооцоотой тооцоолж үзэхэд танкнуудын өдөр тутмын усны хэрэглээний 16-20%-тай тэнцэнэ тэгвэл эргэлтээр ашиглах усны тооцоог тооцсоноор тус үйлдвэр нь хоногт 43.0 м³, сард 1305.4 м³, жилд 15687.8 м³ ус ашиглагдахаар байна.

Бодит ашиглалдаж буй ус зарцуулалтаар: Үйлдвэрийн угаах цех нийт 5 танктай бөгөөд өдөрт 1, 2-р танк 7.5 м³, 3,4,5-р танк 6.0 м³ ус, ээлжийн явцад гарах алдагдал 1 м³, хуурайшсан ноосонд агуулагддаг ус 2 м³, ээлж дуусах бүрд сав цэвэрлэхэд 3 м³ буюу хоногт 39.0 м³/хон ба үүнээс бодит зарцуулалт 32.0 м³/хон ус ашигладаг байна. Тэгвэл тус үйлдвэр нь жилд 300 хоног ажиллахад хоногт 39.0 м³, сард 1170.0 м³, жилд 11700.0 м³ ашиглагдах бөгөөд бодит зарцуулалт буюу эргэлтээр ашиглах усны хэмжээгээр хоногт 32.0 м³, 960.0 м³, 9600.0 м³ ашиглагдаж байна.

Ногоон байгууламжийн усалгаа, арчилгаа: Усны хэрэглээг тооцохдоо БОНХАЖЯ-ны сайдын 2015 оны А/301 тоот тушаалаар батлагдсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм”-ыг баримтлав. Мод үржүүлэг болон зүлэгжүүлэлтийн усалгааны нормыг 3.6 болон 13-р хавсралтыг ашиглан элсэнцэр хөрсний усалгааны нормоор тооцоолсон болно.

Усалгааг газрын гадаргын налуу, хэлбэржилт, байрлал, цаг уурын нөхцөл зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан хийх ба ялангуяа эхний жилд хөрсний чийгийн горимыг барихын тулд элсэнцэр хөрсөнд 7 хоногт 1 удаа, сард 4 удаа, зөвхөн дулааны улиралд буюу жилд 20 удаа усалгааг хийнэ.

Хүснэгт 7. Ногоон байгууламжийн ус хэрэглээний тооцоо

Мод үржүүлэхэд зарцуулагдах усны норм, л						
№	Нэр	Норм, л	Тоо ширхэг	7 хоногт / 1 удаа/	Сард /4 усална/	Жилд /20 удаа/
1	Шилмүүст мод	40.0	110	4400	17600	88000
Нийт: 7 хоногт 4400 буюу 4.4 м ³ /хоног, 17.6 м ³ /сар, 88.0 м ³ /жил						

Нийт ус хэрэглээ:

“БОНХАЖЯ-ны сайдын 2015 оны А/301 тоот тушаалаар батлагдсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм”-р эргэлтийн ус хэрэглээг тооцохгүйгээр тооцоолсон нийт дүн

- Ажилчдын унд-ахуйн хэрэглээ: 52 хүн * 80 л/ажилтан = 4.1 м³/хон, 124.8 м³ /сар, 1248.0 м³ /жил
- Технологийн усны хэрэглээнд: 66.7*280 тн/жил.ноолуур = 51.3 м³/хон, 1554.1 м³/сар, 18676.0 м³ /жил
- Ногоон байгууламжийн усалгаанд: 110 ш мод * 40 л = 4.4 м³/хон, 17.6 м³/сар, 88.0 м³/жил

Нийт 59.8/м³/хон, 1696.5 м³/сард, 20012.0 м³/жил ус шаардагдана.

“Лоро Пьяна Монгол” ХХК -ийн “Ноолуур боловсруулах үйлдвэр” төслийн технологийн ус хэрэглээг төслийн талбай дахь 40м гүн, 5.0 л/с буюу 432.0 м³ ундаргатай худгаас, унд ахайн ус хэрэглээг Ус сувгийн удирдах газрын 2020.06.02 өдрийн “Цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах гэрээний дагуу Улаанбаатар хотын хотын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрээс хангаж байна. Төслийн технологи, унд ахуйн болон ногоон байгууламжийн усны хэрэглээ хоногт 59.8 м³/хоног ус буюу төслийн талбайд байрлах худгийн ундрагын 13.8 %-тай тэнцэж байгаа бөгөөд усны ашиглах боломжит нөөцийн хэмжээ хүрэлцээтэй байна.

Нийт ус хэрэглээ:

“БОНХАЖЯ-ны сайдын 2015 оны А/301 тоот тушаалаар батлагдсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм”-р эргэлтийн ус хэрэглээг хасч тооцоолсон нийт дүн

- Ажилчдын унд-ахуйн хэрэглээ: 52 хүн * 80л/ажилтан = 4.1 м³/хон, 124.8 м³/сар, 1248.0 м³/жил
- Технологийн усны хэрэглээнд: 66.7*280 тн/жил.ноолуур/эргэлтийн ашиглалтын тооцоо = 43.0 м³/хон, 1305.4 м³/сар, 15687.8 м³/жил
- Ногоон байгууламжийн усалгаанд: 110 ш мод * 40л = 4.4 м³/хон, 17.6 м³/сар, 88.0 м³/жил

Нийт 51.5 м³/хон, 1447.8 м³/сар, 17023.8 м³/жил ус шаардагдана.

“Лоро Пьяна Монгол” ХХК -ийн “Ноолуур боловсруулах үйлдвэр” төслийн технологийн ус хэрэглээг төслийн талбай дахь 40м гүн, 5.0 л/с буюу 432.0 м³ ундаргатай худгаас, унд ахайн ус хэрэглээг Ус сувгийн удирдах газрын 2020.06.02 өдрийн “Цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах гэрээний дагуу Улаанбаатар хотын хотын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрээс хангаж байна. Төслийн технологи, унд ахуйн болон ногоон байгууламжийн усны хэрэглээ хоногт 51.5 м³/хоног ус буюу төслийн талбайд байрлах худгийн ундрахын 11.9%-тай тэнцэж байгаа бөгөөд усны ашиглах боломжит нөөцийн хэмжээ хүрэлцээтэй байна.

Нийт ус хэрэглээ:

“БОНХАЖЯ-ны сайдын 2015 оны А/301 тоот тушаалаар батлагдсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм” болон тус үйлдвэрийн бодит тооцоогоор тооцоолсон нийт дүн

- Ажилчдын унд-ахуйн хэрэглээ: $52 \text{ хүн} * 80 \text{ л/ажилтан} = 4.1 \text{ м}^3/\text{хон}$, $124.8 \text{ м}^3/\text{сар}$, $1248.0 \text{ м}^3/\text{жил}$
- Технологийн усны хэрэглээнд: $39.0 * 300 \text{ хоног} = 39.0 \text{ м}^3/\text{хон}$, $1170.0 \text{ м}^3/\text{сар}$, $11700.0 \text{ м}^3/\text{жил}$
- Ногоон байгууламжийн усалгаанд: $110 \text{ ш мод} * 40 \text{ л} = 4.4 \text{ м}^3/\text{хон}$, $17.6 \text{ м}^3/\text{сар}$, $88.0 \text{ м}^3/\text{жил}$

Нийт $47.5 \text{ м}^3/\text{хон}$, $1312.4 \text{ м}^3/\text{сар}$, $13036.0 \text{ м}^3/\text{жил}$ ус шаардагдана.

“Лоро Пьяна Монгол” ХХК -ийн “Ноолуур боловсруулах үйлдвэр” төслийн технологийн ус хэрэглээг төслийн талбай дахь 40м гүн, 5.0 л/с буюу 432.0 м^3 ундаргатай худгаас, унд ахуйн ус хэрэглээг Ус сувгийн удирдах газрын 2020.06.02 өдрийн “Цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах гэрээний дагуу Улаанбаатар хотын хотын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрээс хангаж байна. Төслийн технологи, унд ахуйн болон ногоон байгууламжийн усны хэрэглээ хоногт $47.5 \text{ м}^3/\text{хоног}$ ус буюу төслийн талбайд байрлах худгийн ундаргын 10.9 %-тай тэнцэж байгаа бөгөөд усны ашиглах боломжит нөөцийн хэмжээ хүрэлцээтэй байна.

Нийт ус хэрэглээ:

“БОНХАЖЯ-ны сайдын 2015 оны А/301 тоот тушаалаар батлагдсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм” болон тус үйлдвэрийн бодит тооцоо болон эргэлтийн ус хэрэглээг хасч тооцоолсон нийт дүн

- Ажилчдын унд-ахуйн хэрэглээ: $52 \text{ хүн} * 80 \text{ л/ажилтан} = 4.1 \text{ м}^3/\text{хон}$, $124.8 \text{ м}^3/\text{сар}$, $1248.0 \text{ м}^3/\text{жил}$
- Технологийн усны хэрэглээнд: $32.0 * 300 \text{ хоног/эргэлтийн ашиглалтын тооцоо} = 32.0 \text{ м}^3/\text{хон}$, $960.0 \text{ м}^3/\text{сар}$, $9600.0 \text{ м}^3/\text{жил}$
- Ногоон байгууламжийн усалгаанд: $110 \text{ ш мод} * 40 \text{ л} = 4.4 \text{ м}^3/\text{хон}$, $17.6 \text{ м}^3/\text{сар}$, $88.0 \text{ м}^3/\text{жил}$

Нийт $40.5 \text{ м}^3/\text{хон}$, $1102.4 \text{ м}^3/\text{сар}$, $10936.0 \text{ м}^3/\text{жил}$ ус шаардагдана.

“Лоро Пьяна Монгол” ХХК -ийн “Ноолуур боловсруулах үйлдвэр” төслийн технологийн ус хэрэглээг төслийн талбай дахь 40м гүн, 5.0 л/с буюу 432.0 м^3 ундаргатай худгаас, унд ахайн ус хэрэглээг Ус сувгийн удирдах газрын 2020.06.02 өдрийн “Цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах гэрээний дагуу Улаанбаатар хотын хотын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрээс хангаж байна. Төслийн технологи, унд ахуйн болон ногоон байгууламжийн усны хэрэглээ хоногт $40.5 \text{ м}^3/\text{хоног}$ ус буюу төслийн талбайд байрлах худгийн ундрахын 9.4 %-тай тэнцэж байгаа бөгөөд усны ашиглах боломжит нөөцийн хэмжээ хүрэлцээтэй байна.

Хүснэгт 8. Худгийн мэдээлэл

Худгийн байршлын солбицол	Өргөрөг	Уртгаг
		$47^{\circ}54'06.47''\text{N}$
Цооногийн гүн	40.0 м	
Цооногийн ашиглалтын усны ундарга	5.0 л/с	
Худаг гаргасан он	2008 он	

2. БАЙГАЛЬ ОРЧНЫ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

2.1. Байгаль орчны бүрдэл хэсэгт үзүүлэх болзошгүй сөрөг нөлөө

2.1.1. БОННУ-ээр тогтоосон нөлөөллүүд

Төслийн үйл ажиллагаанд хийсэн байгаль орчны нөлөөллөөр дараах асуудлуудад нэмэлтээр тодотгосон үнэлгээ хийсэн байна.

Хүснэгт 9. БОННУ-ний тодотгол хийгдсэн нөлөөллүүд

№	Байгаль орчны бүрдэл хэсгүүд	Нөлөөллийн шалтгаанууд	Тодорхойлогдсон нөлөөллүүд
1	Газар	БОАЖСайд, БХБСайдын хамтарсан 2018 оны А/02/01 тушаалаар баталсан “Ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хязгаарлалт, хориглолтын бүсийг тогтоосноор уг бүстэй давхцалтай болсон.	Хууль, эрх зүйн орчны шинэчлэл төслийн эмзэг байдлыг нэмэгдүүлнэ.
2	Ус	- Үйлдвэрт ашиглаж байгаа усны байгаа нормоор тогтоосон усны хэмжээнээс бага - Цэвэрлэх байгууламжийг шинэчилснээр үйлдвэрийн бохир усыг 98.0 -аас дээш хувиар цэвэрлэх болсон.	Технологийн шинэчлэл нь бохир уснаас үүсэх сөрөг нөлөөллийг арилгах боломжтой.
3	Хөрсөн бүрхэвч	Үйлдвэрийн үйл ажиллагаанаас хөрсөнд үзүүлэх нөлөө тогтворжсон	Нөлөөллийг үнэлэх шаардлагагүй
4	Ургамлан нөмрөг	Үйлдвэрийн үйл ажиллагаанаас ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөө тогтворжсон	Нөлөөллийг үнэлэх шаардлагагүй
5	Хүний эрүүл мэнд	Төслийн бүс нутаг нь үйлдвэр, технологийн нөлөөллөөр бүрэн өөрчлөгдсөн орчин болсон.	Үйлдвэрийн буюу ажлын баран дээр хүний эрүүл мэндийг хамгаалах шаардлагатай.

Газрын нөөцийн ашиглалт: Төслийн БОННУ-нд газрын нөөц ашигласнаас үүсэж байгаа нөлөөллийн гадаад болон дотоод шалтгааны авч үзээд дотоод шалтгаантай нөлөөллүүд тогтворжсон, гадаад шалтгаантай нөлөөллүүд цаашдыг үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүйг тодорхойлсон.

Хүснэгт 10. Газар ашиглалтын тодотгол ба дүн шинжилгээ

№	Газар ашиглалтын процесс	Нөлөөлөл	Үр дагавар	Хүлээлт
1	Газар ашиглалтын үйл явц 20 гаруй жил үргэлжилсэн	газрын гадаргын хэлбэр дүрс өөрчлөгдсөн	Дасан зохицсон	Ашиглах боломжит зай бага
2	Төслийн талбай дээрх хамгийн сүүлийн барилгажилт 2009 онд хийгдсэн	Өөрчлөлтийн үр нөлөө тогтворжсон.	Дасан зохицсон	Тэлэлтийн орон зай нэн бага
3	Газар ашиглах эрхийг 5, 5 жилээр сунгаж ирсэн.	Газар ашиглалтын эрхээр үйл ажиллагааны эрх хязгаарлагдана.	Үе шаттай үнэлгээнд хамрагдана.	Цаг үед нийцсэн баримт бичгийн бүрдүүлбэр шаардана.
4	2018 оны А/02/01 тушаалаар баталсан “Ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хязгаарлалт, хориглолтын бүс”-гэй давхцалтай болсон.	Төсөл хэрэгжүүлэгчид тавигдах шаардлага чангарна.	Хуулийн өөрчлөлтөд эмзэгшинэ.	Газар ашиглалтын зориулалт өөрчлөгдөж болзошгүй.

2.1.2. Төслийн үйл ажиллагаатай холбоотой нөлөөллийн тодорхойлолт

Ноолуур боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаатай холбоотой нөлөөллийг БОННУ-ний ангилал, төрөлтэй холбогдуулан дараах байдлаар тодорхойлж байна.

Хүснэгт 11. Төслийн үйл ажиллагаатай холбоотой нөлөөллийн тодорхойлолт

№	Үйл ажиллагааны үзүүлэлтүүд	БОННУ-нд ангилалд хамаарах нөхцөл
1	Үйлдвэрт нийт 52 ажилчин, ажилтантай	Жижиг дунд үйлдвэрийн ангиллаар “ДУНД” үйлдвэрлэлд хамаарах бөгөөд өмнө нь 2018 онд хийлгэсэн БОННУ-ний үеийнхээс өөрчлөгдөөгүй.
2	Үйлдвэр жилдээ 350.0 тн ноолуур боловсруулдаг нь жижиг үйлдвэрийн ангилалд хамаарна.	Үйлдвэрийн хүчин чадал 2018 оны БОННУ-нээс хойш өөрчлөгдөөгүй байна.
3	Ноолуур боловсруулах үйлдвэр нь 3 төрлийн агуулах, 5 дамжлагат технологийн цехүүдтэй.	Үйлдвэрийн техникийн ашиглалт, хүчин чадал өөрчлөгдөөгүй.
4	Үйлдвэрт химийн 3 төрлийн бодис, ноолуурын угаалгад хэрэглэгдэх 1 төрлийн бодисыг хэрэглэж байгаа.	Цэвэрлэх байгууламжийн технологи нь химийн цэвэрлэх технологиос хими-биологийн аргаар цэвэрлэх технологид шилжсэнээр исэлдүүлэгч бактери хэрэглэж эхэлсэн.
5	Цэвэрлэх байгууламждаа технологийн шинэчлэл хийж байгаатай холбогдуулан 2021 онд зураг төсөл захиалж хийлгэсэн.	“Хими болон биологийн аргаар ус цэвэршүүлэх байгууламж”-ийн шинэчлэлийн ажлыг үндсэндээ дуусгасан ба бохир усны цэвэршилтийн түвшин 99.7 хувьд хүрээд байна.
6	Цэвэрлэх байгууламжийн биологийн биет буюу исэлдүүлэх бактери нь 15°C-ээс хүйтэн болоход амьдрах чадваргүй болно.	Цэвэрлэх байгууламжийн лагийн өвөлжилтийн байдлыг үнэлнэ.

2.1.3. Усны ашиглалтаас үүсэх нөлөө

Ноолуур боловсруулах үйлдвэр нь цэвэр усыг унд, ахуйн хэрэгцээнд хэрэглэхээс гадна үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах ба технологийн хэрэгцээний усыг өөрийн эзэмшлийн гүний худгаас цэвэр ус шууд татан хэрэглэдэг. Туул голын сав газрын захиргаанаас “Лоро Пьяна Монгол” ХХК-ийн ноолуур боловсруулах үйлдвэрт тооцсон ус ашиглуулах дүгнэлтээр жилд 16,008м³/жил ус ашиглана гэсэн тоолуурын заалтаар гүний худгаас татан ашиглаж байгаа усны зарцуулалт нормоос бага байгаа юм.

Хүснэгт 12. Төслийн усны бодит хэрэглээ, ус ашиглалтын нормоор тооцсон хэмжээ

№	Ус хэрэглэх шалтгаан, хэрэгцээ	Үйлдвэрийн усны бодит хэрэглээ	БОНХСайдын 2015 оны А/301 тоот тушаалаар баталсан норм
1	Ноолуур угаах технологийн усны хэрэгцээ	Үйлдвэрийн зарцуулалтаар хоногт 1.21 тн ноолуур боловсруулахад 30 м ³ /хоног буюу 8,000.0 м ³ /жил усыг худгаас татаж ашиглаж байгаа нь цэвэршүүлсэн усны хэмжээгээр багасна.	Усы газраас ирүүлсэн 2023-10-13-ны өдрийн 01/1226 тоот албан бичигт тусгаснаар “Лоро Пьяна Монгол” ХХК-ий эзэмшлийн худаг нь ноолуур боловсруулах үйлдвэрийн усны хэрэгцээнд хүрэлцээтэй байна.
2	Ажилчдын унд, ахуйн болон үйлдвэрийн цэвэрлэгээний зориулалттай усны хэрэглээ	Үйлдвэрийн усны төлбөр, тоолуурын заалтаар усны хэрэглээгээр сард дунджаар 860-880 м ³ /жил усыг технологийн бус зориулалтаар хэрэглэж байна. Энэ нь нормын хэрэглээнээс 13.0 хувиар багаа байгаа юм.	Нормоор тооцсон ахуйн нийт хэрэглээ 999.9 м ³ /жил болох ба үүнээс: <ul style="list-style-type: none"> • Ажилчдын унд ахуйн хэрэглээнд А/301-ын 4 дүгээр хавсралтаар 39 хүн <ul style="list-style-type: none"> • 2.5м³= 97.5 м³/жил (9.7%) • Оффисын ажилтнуудын усны хэрэглээ 14-р хавсралтаар 15 хүн * 80л = 1,200.0

			<ul style="list-style-type: none"> • л/хоног * 266.0 өдөр = 319.2 м3/жил (31.9%) • Оффис, үйлдвэрийн цэвэрлэгээнд 8л * 972 м2 = 7,776.0 л/удаа * 75 удаа = 583.2 м3/жил (58.4%)
3	Үйлдвэрийн орчны ногоон байгууламжийн усалгаа	Үйлдвэрийн хаягдал усыг цэвэршүүлснээр ногоон байгууламжийн усалгаанд ашиглах боломжтой.	Цэцэрлэг, ногоо услах нормоор 1497.7м ² * 4л = 5,990.8л * 2 удаа = 12.0 м ³ жил ус болно.

2.2. Ноолуур боловсруулах үйлдвэрийн ажлын байрны орчин

Ноолуур боловсруулах үйлдвэрийн ажлын байрны орчинд хийсэн хэмжилт судалгаанд үндэслэн нөлөөллийг дараах байдлаар тодорхойлж байна.

Хүснэгт 13. Ажлын байрны орчин, нөхцөлүүдээс үзүүлэх нөлөөллийн тодорхойлолт

№	Үзүүлэлтүүд	Хэмжилтийн тодорхойлолт ⁴	Нөлөөллийн тодорхойлолт
1	Ажлын байрны бичил цаг уур	Үйлдвэрийн самнах ялгах цех дэх технологи ажиллагаа нь 20-24 хэмийн дулаантай, 75-85% хувийн агаарын харьцангуй чийгшилтэй орчинд явагддаг онцлогтой ч судалгаагаар дулааны үзүүлэлт нь стандартаас бага, агаарын харьцангуй чийгшлээр стандартаас их байна.	<ul style="list-style-type: none"> • Шинэ технологиор ажиллах цэвэрлэх байгууламжийн орчны ажлын байрны нөхцөлд онц өөрчлөлт ороогүй • Хөдөлмөр хамгааллын нэмэлт шаардлага тавигдаагүй. • Ажилчдыг хамгаалах хүрээнд төсөл хэрэгжүүлэгчийн баримталж буй бодлогод өөрчлөлт ороогүй
	Ажлын байрны физик бохирдол	Үйлдвэрийн үндсэн цех, дамжлага дээр дуу чимээний түвшин стандартаас 60.0 орчим хувиар их байна.	
2	Ажлын байрны тоосжилт	Лабораторийн орчинд тоосжилт хамгийн бага, ноолуур боловсруулах үйлдвэрийн дамжлагын преслэх хэсэгт ажлын байран дээр тоосжилт харьцангуй бага байна. Харин ноолуур самнах цехэд Хятад дамжлагын ажлын байрны агаар дахь тоосны дэгдэлт хамгийн өндөр, япон дамжлагынхаас 1.19-4.3 дахин их байна.	

2.3. Хог хаягдлын эх үүсвэртэй холбоотой нөлөөллийн тодорхойлолт

Төслийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайланд үйлдвэрийн хог хаягдлын эх үүсвэр болон төрөл, ангиллын талаар маш дэлгэрэнгүй авч үзсэнд үндэслэн төслийн үйл ажиллагааны явц дахь хог хаягдлын нөлөөллийг дараах байдлаар тодорхойлж байна.

Хүснэгт 14. Төслийн хүрэн дэх хог хаягдлаас үүсэх нөлөөллийн тодорхойлолт

№	Хог хаягдлын үзүүлэлт	Хог хаягдлын эх үүсвэр	Нөлөөллийн тодорхойлолт
1	Ангилгдахгүй энгийн хатуу хаягдал	<ul style="list-style-type: none"> • Нийтийн хоолны үйлчилгээ • Ариун цэврийн үйлчилгээ 	Нэн бохирдолтой, органик гаралтай тул амархан исэлдэх онцлогтой.
2	Ангилгдах хатуу энгийн хаягдал	<ul style="list-style-type: none"> • Үйлдвэрийн технологи • Ажилчдын хэрэглээ • Барилга байгууламжийн ашиглалт • Тоног төхөөрөмжийн ашиглалт 	Хог хаягдлын ангилал, төрлийн задаргаа нь үйлдвэрийн бэлтгэсэн ангилалд тохирохгүй байж болзошгүй.

3	Ахуйн бохир шингэн	<ul style="list-style-type: none"> • Нийтийн хоолны үйлчилгээ, • Ариун цэврийн үйлчилгээ • Үйлдвэрийн цэвэрлэгээ, үйлчилгээ 	Үйлдвэрийн цэвэрлэх байгууламжаар дамжихгүй.
4	Аюултай хог хаягдал	<ul style="list-style-type: none"> • Химийн бодисын сав баглаа • Угаах цэхийн шингэх бохир • Лабораторийн химийн бодис • Оффисын орчин • Барилгын ашиглалт • Тоног төхөөрөмжийн ашиглалт Тээврийн хэрэгслийн ашиглалт 	Үйлдвэрийн аюултай хаягдал олон төрөлтэй байгаа нь Цэцүүх трейд ХХК-тэй хийсэн гэрээнд бүгд хамрагдахгүй байж болзошгүй.
5	Үйлдвэрийн бохир шингэн	<ul style="list-style-type: none"> • Цэвэрлэх байгууламжийн саарал ус 	Цэвэрлэх байгууламжийн технологийн горим доголдож болзошгүй
6	Агаар бохирдуулагч хийн хаягдал	<ul style="list-style-type: none"> • Цэвэрлэх байгууламж • Ажлын байрны тоосжилт 	Ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй.

3. 2026 ОНЫ ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”-д зааснаар “Лоро Пьяна Монгол” ХХК-ийн “Хими болон биологийн аргаар бохир ус цэвэршүүлэх байгууламж” төсөл нь тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, үнэлгээний тайлангийн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллах үүргийг хүлээнэ.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгана. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласнаар доорх зорилтуудыг хангана. Үүнд:

- Байгаль орчны хууль тогтоомжийн холбогдох зүйл заалт, журам заавар, стандартын шаардлагад нийцүүлэн төслийн үйл ажиллагааг явуулна.
- Байгаль орчны менежментийн асуудлаар БОННУ-ний тайланд боловсруулан тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмжүүдийг хэрэгжүүлнэ.
- Ажилчид байгаль орчны хамгаалах асуудалтай холбоотой үүрэг хариуцлагаа ойлгосон байх, сургалтанд хамрагдах боломжтой болно.
- Байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, эрсдэлийг урьдчилан тооцсоноор байгальд шууд болон шууд бус хэлбэрээр үзүүлэх нөлөөллийг бууруулах, байгаль орчны төлөв байдлыг хадгалж, хамгаална.
- Сум орон нутгийн удирдлага, тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа, хяналтын байгууллага, ард иргэдтэй байгаль хамгаалах асуудлаар зөвлөлдөж, тэдний саналыг авч хамтран ажиллах нөхцөл бүрдэнэ.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

“Лоро Пьяна Монгол” ХХК-ийн “Хими болон биологийн аргаар бохир ус цэвэршүүлэх байгууламж” төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн цар хүрээ, эрчмийг харгалзан үзэж, түүний нөлөөллийн бүсийн талбайг хамруулан байгаль орчны хяналт шинжилгээний мониторингийн системийг байгуулах нь зүйтэй. Тухайн төслийг хэрэгжүүлснээс үүдэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, шинээр үүсэн бий болсон нөхцөл байдалд ажиглалт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг “орчны хяналт шинжилгээний хөтөлбөр” /ОХШХ/ гэнэ. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь төслийг хэрэгжүүлэх явцад үүссэн сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах үйл ажиллагаа ямар үр дүнтэй байгааг илтгэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулах, орон нутгийн захиргаа болон нутгийн оршин суугчдад бодитой мэдээлэл өгөхөд чухал ач холбогдолтой.

Агаар орчин

ОХШХ-т тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх, сорьцын шинжилгээний төрөл хэлбэрийг хөтөлбөрт тусгагдсаны дагуу графикт хугацаанд нь хийлгэж, дүгнэлт гаргуулж байх, шаардлагатай тохиолдолд холбогдох арга хэмжээг авна. Хийн бохирдлын менежмент нь хүний эрүүл мэндийг хамгаалах, амрагч, ажилчид, нутгийн оршин суугчдын ажиллах, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн байх ёстой буюу

төлөвлөлтийн холбогдох үндсэн шалгуурууд агаарт хаяж буй бохирдуулагчдад тавигдах ёстой.

Усны чанар

Усны чанарын шинжилгээг төсөл хэрэгжих хугацаанд хийлгэх хяналт шинжилгээг графикт хугацаанд нь шинжилгээ хийлгэж, дүгнэлт гаргуулан, бохирдол илэрсэн тохиолдолд мэргэжлийн байгууллагатай хамтран түүнийг арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Хөрсөн бүрхэвч

Хөрсний бохирдлын түвшинг дотоодын магадлан итгэмжлэгдсэн лабораториор гүйцэтгүүлэх, хяналт шинжилгээний хөтөлбөрт тогтоосон сорьц авах цэгүүд дээр үргэлжлүүлэх, сорьцын шинжилгээний төрөл хэлбэрийг орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсаны дагуу графикт хугацаанд нь хийлгэж дүгнэлт гаргуулж байх.

Ургамлан нөмрөг

Төслийн үйл ажиллагааны үед эвдрэлд орсон талбайн нөхөн сэргээлтийг мэргэжлийн байгууллагаар хийлгэх, ургамлан нөмрөгийн мониторинг судалгааг төслийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсаны дагуу графикт хугацаанд нь хийлгэж дүгнэлт гаргуулж байх.

Амьтны судалгаа

Ан амьтныг судлах, хамгаалах, хяналт тавих талаар амьтан судлаачидтай хамтран ажиллах, төслийн талбайн орчимд тохиолдох ховор, нэн ховор болон экологийн ач холбогдол бүхий амьтдын бүртгэл, фото зураг, холбогдох мэдээллийг цуглуулж, мэргэжлийн байгууллагаар судалгаа хийлэх мөн ажилчдад танилцуулах, тэдгээрийг хамгаалах, тоо толгойг нэмэгдүүлэх арга хэмжээг орон нутгийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх боломжтой юм.

4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл, өртөгч	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ (5 жилээр)	Нэгж зардал (.төг)	Нийт зардал (.төг)	Хэрэгжүүлэгч	Хамтран хэрэгжүүлэгч	Биелэлтийн шалгуур	Баримтлах хууль журам, стандарт, аргачлал
Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ									
Хийн хаягдал, Тоосжилт	Үйлдвэрийн дотоод орчны шаардлагатай байршлуудад агаарын чийгшил, температур зэргийг өөрсдийн багажаар тогтмол хэмжилт хийж тэмдэглэл хөтлөх.	Агаарын чанар		-	800,000	“Лоро Пьяна Монгол” ХХК	Үйлдвэрийн ХАБ, БОМ	ТЖБОБТ Тэмдэглэл	Агаарын тухай хуулийн Агаарын чанар Техникийн ерөнхий шаардлага MNS: 4585-2025
	Орчны агаарын чанарын хэмжилт хийх, мэргэжлийн байгууллагаар шинжилгээ хийлгэж, түвшинг тодорхойлуулан, заавар зөвлөмж авч ажиллах	Агаарын чанар	Жилд 2-өөс доошгүй удаа	ОХШХ-т тусгагдсан.			Мэргэжлийн байгууллага, судлаач	Шинжилгээн ний дүн	
	Үйлдвэрийн хятад цехийн дулааны алдагдлыг багасгах зорилгоор цонхны дулаалга, давхар цонх хийх	Агаарын чанар	-	Үйл ажиллагааны зардалд тусгах			-	ТЖБОБТ	
Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ									
Ус ашиглалт, Усны нөөц зөв зохистой ашиглах, усны чанарт үзүүлэх нөлөөлөл	Ажилчдын унд- ахуйн хэрэглээнд ашиглах усанд эрүүл Ахуйн шинжилгээг хийлгэж байх	Гадаргын болон гүний усны нөөц, чанар	Жилд 2-өөс доошгүй удаа	ОХШХ-т тусгагдсан		“Лоро Пьяна Монгол” ХХК	Итгэмжлэгдсэн лаборатори	ТЖБОБТ	“Усны тухай” хууль, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль, MNS 7003:2023, MNS 5666:2006 “MNS 0899 : 2020 Унд ахуйн зориулалттай төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийг сонгох журам ба эрүүл ахуй, техникийн шаардлага
	Ус ашигласан төлбөрийг төлөх		Усны тоолуурын заалтаар		Усны газар		Дүгнэлт		
	Ус ашиглуулах дүгнэлт, зөвшөөрөл авч, гэрээ байгуулах		Мөнгөн дүн тусгах шаардлагагүй						
	Хаягдал усны дүгнэлт гаргуулах		Мөнгөн дүн тусгах шаардлагагүй						
	Стандарт хэмжил зүйн газраар усны тоолуурын баталгаажуулалтыг тогтмол хийх		-	150,000	Стандарт хэмжил зүйн газар		Тоолуурын баталгаажилтын хугацаагаар		
	Цэвэрлэх байгууламжтын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавих, шаардлагатай тохиолдолд засварыг хийх			250,000				Үйлдвэрийн ХАБ, БОМ	
Лагийн чийгийн агууламж, хатуу хольцын агууламж, эзлэхүүн зэрэг лагийн үзүүлэлтийг тогтмол хянаж, бүртгэх		Тогтмол	-	100,000	Үйлдвэрийн ХАБ, БОМ	ТЖБОБТ,			

	Лагийг өтгөрүүлэх, усгүйжүүлэх, болон цэвэрлэх байгууламжийн тоног төхөөрөмжийн урьдчилсан засвар үйлчилгээг тогтмол хийх , хяналт тавих		Тогтмол	-	500,000		Үйлдвэрийн ХАБ, БОМ	ТЖБОБТ,	
	Борооны усыг хуримтлуулан ногоон байгууламжийн усалгаанд ашиглах		Нэг удаа	-			Үйлдвэрийн удирдлага	ТЖБОБТ,	
Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, газрын гадаргад үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ									
Ургамлан нөмрөг талхлагдах, хөрсөн бүрхэвч бохирдох	Төсөл хэрэгжих талбай, хашаанаас гадна хог хаягдал хаяхгүй, газрын гадарга, хөрсийг эвдэхгүй, хөндөхгүй байх арга хэмжээг хэрэгжүүлж байх	Ойр орчмын хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг	Тогтмол	Үйл ажиллагааны зардалд тусгах		“Лоро Пьяна Монгол” ХХК	ХАБ, БОА,	ТЖБОБТ	Хог хаягдлын тухай хууль, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, MNS 5914:2008 Байгаль орчныг хамгаалах тухай хууль MNS 5850:2019– Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
	Эзэмшил газрын хог хаягдлыг цэвэрлэх, эвдэрсэн хөрсийг засаж тэгшлэх,		400,000		ХАБ, БОА		ТЖБОБТ,		
	Эдэлбэр газар, түүний эргэн тойрны хариуцан хамгаалах талбайг хог хаягдалгүй, цэвэр цэмцгэр байлгах		400,000		ХАБ, БОА		ТЖБОБТ,		
Нийт: 2,200,000									

5. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжүүлэгч “Лоро Пьяна Монгол” ХХК нь төслийн талбайн сул чөлөөтэй хэсгүүдэд ногоон байгууламж тарималжуулалтын ажлыг хангалттай хийж гүйцэтгэсэн хэдий ч “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд ногоон байгууламж байгуулах, тарималжуулах ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэх, тохижилт ногоон байгууламжийн талбайг нэмэгдүүлэх ажлыг тасралтгүй үргэлжлүүлэх нь зүйтэй иймд төслийн талбайд ногоон байгууламж байгуулах сул чөлөөтэй талбай бага тул ногоон байгууламж тарималжуулалтын ажлыг дүйцүүлэх байдлаар өөр байршилд буюу Хан-уул дүүрэг хорооноос тодорхойлсон газарт тариалахыг зөвлөж байна.

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт
Элэгдэл эвдрэлд орсон газрыг нөхөн сэргээн, ногоон байгууламж бий болгох	Орчны тохижилтыг сайжруулан, талбайд ногоон байгууламж хийх	Улиас	1-5 нас	25	7500	187,500	Төсөл хэрэгжих хугацаанд	- Байгаль орчин, эвдэрсэн газрын техникийн нөхөн сэргээлт - MNS5914:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт, хамгаалалт.MNS5916:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах, техникийн ерөнхий шаардлага.
		Хайлаас	1-5 нас	25	5000	125,000		
Нийт				50		315,500		
Арчилгаа, тордлогоо	Ногоон байгууламжийн усалгаа тайралт, хэлбэржүүлэлт хийх	Агротехникийн ажиллагаа				500,000		
Нийт дүн 815,500								

6. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хог хаягдлын ангилал	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгж зардал (.төг)	Нийт зардал (.төг)	Хэрэгжүүлэгч	Баримтлах хууль журам, стандарт, аргачлал
Ахуйн болон химийн аюултай хатуу хог хаягдал	Төслийн талбайд байрлаж буй хатуу хог хаягдлыг түр хураан хадгалах зориулалтын савны битүүмжлэл бүхий хог хаягдлыг ангилан ялган тэмдэг тэмдэглэгээгээ бүхий стандартын шаардлагыг хангуулахаар тогтмол хяналт тавих эвдэрсэн тохиолдолд сайжруулах, засварлах	Төслийн хүрээнд	Удаа	-	200,000	“Лоро Пьяна Монгол” ХХК	“Хог хаягдлын тухай хууль”, Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр, БОАЖ сайдын 2018.11.17 өдрийн А/443 дугаар тушаал Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам MNS 5344:2003
	“Хог хаягдлын гэрээ” байгуулан, гэрээний дагуу хог хаягдлыг төвлөрсөн цэгт зөөж зайлуулах, тээвэрлүүлэх	Төслийн хүрээнд	Удаа	Гэрээнд заасан төлбөрийн хэмжээгээр. Үйл ажиллагааны зардалд тусгагдсан.			
	Хог хаягдлыг ангилах талаар ажилчдад сургалт орох	Үйлдвэрийн бүх ажилтан	Жилд 1 удаа	600,000			
	Хог хаягдлыг ангилах талаар мэдээллийн самбар байрлуулах	Төслийн хүрээнд	ш	350,000			
	Эдэлбэр газар, түүний эргэн тойрны хариуцан хамгаалах талбайг хог хаягдалгүй, цэвэр цэмцгэр байлгах	Ойр орчмын 50 метр газарт	Тогтмол	Үйл ажиллагааны зардалд тусгах			
	Үйлдвэрээс гарах лаг шаврын хаягдлыг тогтмол тээвэрлэх устгах	Төслийн хэмжээнд	Тогтмол				
Удаан задардаг хатуу хог хаягдал үүсэх	Дахин боловсруулагдах хог хаягдлыг цуглуулан хоёрдогч түүхий эд авах байгууллага, нэгжид нийлүүлэх, гэрээ байгуулах	Төслийн хүрээнд	Тухай бүр т нь	-	-		
Ялаа шавж үржих, өвчин гарах	Хог хаягдлын цэгт ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх, орчныг бохирдуулахаас сэргийлэх	Хатуу хог хаягдлын цэгт	Улирал бүр 1 удаа	250,000			
Нийт зардал			1,400,000 төгрөг				

7. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Гүйцэтгэгч	Баримтлах хууль журам, стандарт, аргачлал
Химийн бодисын ашиглалт, хадгалалтын үе шат					
ХБ-ын хадгалалт, ашиглалтын явцад асгарах, ХХД алдагдсанаар ажиллагсдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх	Химийн бодис хадгалах агуулахын байрыг тогтмол аюулгүй байдлыг ханган, АХХ хадгалах савны бүрэн бүтэн байдлыг хянах	350,000	Ажил эхлэхийн өмнө	“Лоро Пьяна Монгол” ХХК	“Химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам” “Химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам” Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодисын шошго, анхааруулах тэмдэг MNS 5029:2011 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага MNS 6458:2014
	Химийн бодистой ажиллах ажиллагсдыг хөдөлмөр хэрэгслээр бүрэн хангах	-	Тогтмол		
	Ажилчдад химийн бодистой ажиллах зааварчилгаа, сургалт явуулах	1,000,000	Ажил эхлэхийн өмнө		
	Вермикулят, шингээгч материалыг бэлэн байлгаж, яаралтай арга хэмжээ авах төлөвлөгөө боловсруулах	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан	Тухайн нөхцөл бүрдсэн үед		
Химийн бодисын асаралт болсон үед хэрэглэх шингээгч материалыг зохих газруудад байршуулах	250,000	Тогтмол			
Аюултай хог хаягдлыг эх үүсвэр дээр түр хадгалах	Ашиглаж буй химийн бодис нэг бүрээр ашиглалт, зарцуулалтын бүртгэл хөтлөх	-	Тогтмол		
	Аюултай хог хаягдал сард 1000 килограммтай тэнцүү буюу түүнээс бага аюултай хог хаягдал үүсгэдэг бол 180 хоног эх үүсвэр дээр түр хадгалах хуулийг дагаж мөрдөх	-	Тогтмол		
Аюултай хог хаягдлыг устгах	Аюултай хог хаягдлыг устгах мэргэжлийн эрх бүхий байгууллагатай гэрээлэн ажиллаж, аюултай хог хаягдлыг устгах, зайлуулах.	Гэрээнд заасан төлбөрийн хэмжээгээр	Тогтмол		
Ослын эрсдэлээс урьдчилан сэргийлэх					
Химийн бодисын агуулахын битүүмжлэл алдагдаж, агаар, ус, хөрсөөр тархах, ХБ-ын ашиглалтын үед асгарч алдагдах	ХБ-т өртсөн үед яаралтай тусламж үзүүлэх хэрэгсэл, эмийн сан бий болгож, тодорхой газар байрлуулах	200,000	Химийн бодисын ашиглалтын бүх хугацаанд	“Лоро Пьяна Монгол” ХХК	“Гамшгаас хамгаалах тухай хууль” “Галын аюулаас урьдчилан сэргийлэх заавар”
Нийт зардал			1,800,000 төгрөг		

8. УДИРДАГА-ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны удирдлага-зохион байгуулалтын арга хэмжээ							
Сөрөг нөлөөллийг арилга, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нийт зардал	Хэрэгжүүлэгч	Хамтран хэрэгжүүлэгч	Биелэлтийн шалгуур	Баримтлах стандарт ба аргачлал
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж жил бүр батлуулж байх	Төслийн хүрээнд	Жил бүр	-	“Лоро Пьяна Монгол” ХХК	Эрх бүхий мэргэжлийн байгууллага	БОМТ-ний тайлан	Байгаль хамгаалах тухай хуулийн 10 ¹ Газрын тухай хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан журам БОНХЯ-ны сайдын 2014 оны 1-р сарын 06-ны өдрийн А-03 тоот журам БОНХЯ-ны сайдын 2014 оны 1-р сарын 06-ны өдрийн А-03 тоот журам Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагад зөвшөөрөл олгоход тавигдах шаардлага болон зөвшөөрөл олгох журам Хог хаягдлын тухай хууль Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль болон бусад
Батлагдсан БОМТ-г бүх шатны ЗД, байгаль орчны улсын байцаагч, байгаль хамгаалагч, БОУАӨЯ-д хүлээлгэн өгөх	Төслийн хүрээнд	Жил бүр	-			БОБТ	
Ажилчдын дунд байгаль хамгаалах талаар сургалт, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулах - Байгаль орчныг хамгаалах - Гал түймрээс урьдчилан сэргийлэх /шаардлагатай үед гал унтраах багаж хэрэгслийг ашиглаж чаддаг байх/ - Хөдөлмөр хамгаалал	Бүх ажилчид	Жилд 1 удаа	500,000		Байгаль орчны мэргэжилтний оролцоотойгоор	Сургаалтанд хамрагдсан бүртгэл тэмдэглэл	
Орон нутгийн засаг захиргаа, олон нийтийн байгууллага, хорооны иргэдийн саналыг сонсож, зохих арга хэмжээ авах, харилцан мэдээлэл солилцож байх	Төслийн хүрээнд	Орон нутгийн иргэдийн санал хүсэлт	Тухайн үеийн үйл ажиллагааны зардалд тусгагдана.		-	Хурал уулзалтаас гарсан шийдвэр	
Ус, цахилгаан ашигласны болон бусад төлбөрийг төлөх	Төсөвт хувь нэмэр оруулах	Тогтмол	Үйл ажиллагааны зардалд тусгагдана.		-	Төлбөр төлсөн баримт	
Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулж батлуулах	Төслийн хүрээнд	Жил бүр	1,000,000		-	Тайлан, төлөвлөгөө	
Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, худалдах, ашиглах зөвшөөрөл авах	Төслийн хүрээнд	-	-		-	Тусгай зөвшөөрөл	
Галын аюулаас хамгаалах хэрэгслийг байршуулан шалын дүгнэлт гаргуулах	Төслийн хүрээнд	Тогтмол	-		-		
Нийт зардал		1,500.000 төгрөг					

9. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдал алдагдах, осолд өртөх	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сурталчилгааг тогтмол хийж байх, “Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-тай ажилчид танилцаж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж хэвшүүлэх	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа Бүх ажилчдад	Нийт ажилчдын тоогоор /ш/	ХАБЭА-н зардалд тусгах		Сард нэг удаа	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн ангилал, үнэлгээнд тавих ерөнхий шаардлага MNS 5080:2023” стандарт
	Үйлдвэрийн ажилчдад өглөө бүр аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгч гарын үсэг зуруулан баталгаажуулж ажилтныг аюулгүй ажиллах арга барилд байнга сургаж байх	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа	Бүр ажилчдыг хамруулах	ХАБЭА-н зардалд тусгах		Тогтмол	
	Ажлын байрны онцлог чиг үүрэгт тохирсон ажлын гутал, хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслээр хангах	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа Бүх ажилчдад	Бүр ажилчдыг хамруулах	ХАБЭА-н зардалд тусгах		Тогтмол	
	Эмнэлгийн анхан шатны хэрэгслээр тоногдсон ажлын байрны бэлэн байдлыг хангаж, осолд өртсөн ажилтанд анхны тусламж үзүүлэх	Ажилчдын эрүүл мэндийг хамгаалах	Үйлдвэрийн талбайд өрөө бэлдэх	ХАБЭА-н зардалд тусгах		Тогтмол	
Ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдал алдагдах, осолд өртөх	Ажлын байрны гэрэлтүүлгийг жигд хүрэлцээтэй тусаж байхаар ерөнхий болон хэсгийн гэрэлтүүлгийг сайжруулах	Аюулгүй ажиллагаа	Төслийн талбайд	ХАБЭА-н зардалд тусгах		Тогтмол	
	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн ангилал, үнэлгээнд тавих ерөнхий шаардлага MNS 5080:2023” стандартыг мөрдөж ажиллах	Хөдөлмөрийн аюулгүй байдал	Төслийн хүрээнд	ХАБЭА-н зардалд тусгах		Тогтмол	

10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт, хэмжих нэгж	Байршил	Хугацаа ба давтамж	Хяналт шинжилгээний ажлын хэмжээ	Баримтлах стандарт ба аргачлал	Дээд, доод хязгаар	Нэгжийн өртөг мян. төг	Нийт зардал, мян.төг жил
“Лоро Пьяна Монгол” ХХК-ийн “Хими болон биологийн аргаар бохир ус цэвэршүүлэх байгууламж” төслийн Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр							
Агаар: PM10 мкг/м ³ , PM2.5 мкг/м ³ , CO ₂ , мкг/м ³ , Нийт тоосонцор, мкг/м ³ Агаарын чийгшил, % Температур, °C	Авто машины зогсоол Ногоон байгууламж Үйлдвэрийн дотоод орчин самнах, угаах хэсэгт Нийт: 4 цэгт	Жилд 1 удаа	Мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх	Агаарын тухай хууль, MNS 4585:2025, MNS 4585:2016, MNS 5014 : 2009	Стандартад заасан хэмжээтэй харьцуулна.	200.0	800.0
Дуу чимээ: Хамгийн их түвшин, дБА Хамгийн бага, дБА түвшин Дундаж түвшин, дБА		Жилд 1 удаа	Мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх	MNS 4585:2007, Гадаад орчны агаарын түгээмэл зарим бохирдуулагчийн хүлцэх агууламж			
Унд ахуйн ус: Усны химийн шинжилгээ	Унд ахуйн ус буюу гүний худаг болон төвийн шугамаас Нийт:2 цэгт	Жилд 1 удаа	Мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх	MNS 4586:2024 Усан орчны чанар. Ерөнхий шаардлага MNS 0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ		90.0	180.0
Хаягдал усны шинжилгээ	Цэвэрлэх байгууламжаас гарах хаягдал уснаас	Жилд 2 удаа	Мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх	MNS 6561:2024 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага		100.0	100.0
Лагийн шинжилгээ	Цэвэрлэх байгууламжаас гарах лагаас шинжилгээ	Жилд 2 удаа	Мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх	MNS 5666:2006 Усны биологийн шинж чанарын шинжилгээ. Бохир усны цэвэрлэх байгууламжийн идэвхт лагийг тодорхойлох шинжилгээний арга		80.0	160.0
Хөрс: Хөрсний механик бүрэлдэхүүн, физик чанар Агрохимийн чанар Хүнд металл (Ni, Pb, Zn, Cu, Cr) мг/л	Авто машины зогсоол Ногоон байгууламж Нийт: 2 цэгт	Жилд 1 удаа	Мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх	MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ		220	440.0
“Лоро Пьяна Монгол” ХХК-ийн “Хими болон биологийн аргаар бохир ус цэвэршүүлэх байгууламж” төслийн Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн нийт зардал						1,680.000	

11. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах арга хэмжээ							
БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар	Хэрэгжүүлэгч	
БОУАӨЯ	БО-ны мэргэжилтэн дүгнэлтээр баталгаажна.	Тухайн жилийн БОМТ-ний биелэлтийн тайлан	Жил бүрийн 11-р сарын 1	Шинжээчдийн дүгнэлт	БОАЖЯамны холбогдох нэгж, хэсэг	“Лоро Пьяна Монгол” ХХК	“БОНХЯ-ны сайдын 2014 оны 1-р сарын 06-ны өдрийн А-03 тоот журам” Олон нийтийн оролцоо, хяналтыг хэрэгжүүлэх хүрээнд
Бүх шатны Засаг дарга, Байгаль орчны улсын байцаагч, орон нутгийн байцаагч	Хуралд танилцуулах, Уулзалт	БОМТ-ийн тухайн жилийн тайлан, Ирэх оны төлөвлөгөө	12-р сарын 1-ний дотор	БОХ арга хэмжээний тайлан ирэх оны төлөвлөгөөг танилцуулах, санал авах, хамтран ажиллах	Дүүрэг, хороо		
Төрийн захиргааны төв байгууллага	Тайлан, төлөвлөгөөг цаасан хэлбэрээр		12-р сарын 10-ний дотор	Хянуулах батлуулах	Аймгийн байгаль орчны газар		
Үйлдвэрийн БОМТ-ний хэрэгжилтэд ажилтнуудын оролцоо оролцоог таниулах	Хуралд танилцуулах,		-	Үйлдвэрийн БОМТ-ний хэрэгжилтэд ажилтнуудын оролцоо оролцоог нэмэгдүүлэх	ХАБ, БОА		

12. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах арга хэмжээ						
БОМТ хэрэгжилтийг тайлагнах, оролцох талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Тайлагнах зардал	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
БОУАӨЯ-ны ХБОБНУГ-г	Тайлан, төлөвлөгөөг цаасан хэлбэрээр	БОМТ-ийн тухайн жилийн тайлан	Жил бүр 1 удаа	-	-	“Лоро Пьяна Монгол” ХХК
БОУАӨЯ	Тайлан, төлөвлөгөөг цаасан хэлбэрээр	БОМТ-ийн тухайн жилийн тайлан	Тухайн жилийн 11-12 сарын дотор	-	-	

13. ДҮГНЭЛТ

Тус “Лоро Пьяна Монгол” ХХК-ийн “Хими болон биологийн аргаар бохир ус цэвэршүүлэх байгууламж” төсөл нь Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 3-р хорооны нутагт хэрэгжиж байна.

Тус төслийн 2026 оны Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29–ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралтаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулсан болно. 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал **9,395,500** төгрөг зарцуулах урьдчилсан дүн гарсан байна.

Хүснэгт 15. Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөний 2026 оны зардал

Зардлын хэлбэр	Нийт зардал, төг
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний зардал	2,200,000
Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	815,500
Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал	1,400,000
Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1,800,000
Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ	1,500,000
Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	ХАБЭА-н зардалд тусгасан
БОМТ-г хэлэлцүүлэх, тайлагнах зардал	-
Орчны хяналт шинжилгээний зардал	1,680,000
Нийт	9,395,500

Төсөл хэрэгжүүлэгч тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг 11 дүгээр сарын 01-ний дотор төсөл хэрэгжүүлж байгаа аймаг, нийслэлийн байгаль орчны газарт хүргүүлэх шаардлагатай.